



ЭРХ БҮХИЙ ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

**УЛААНБААТАР ХОТЫН  
ГЭР ХОРООЛЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ  
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ  
ХӨТӨЛБӨР ТӨСЛИЙН НЭГЖ**

Соёлын төв өргөө Г корпус 411 тоот,  
Амарын гудамж 2, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200 0061  
Утас: (976) 7000 3099, Факс: (976) 7000 3098  
Цахим шуудан: info@ub-subcenter.mn  
Цахим хуудас: www.ub-subcenter.mn

*2023.08.29* № *927*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Үнийн санал ирүүлэх урилга  
хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэрэгжүүлж буй “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь эрх бүхий тендерт оролцогчдоос Т3-SCS-04 дугаар бүхий “Иргэдэд мэдээлэх төвийн засвар, шинэчлэлтийн ажил”-д үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх урилга, маягт болон техникийн тодорхойлолт, ажлын тоо хэмжээ, холбогдох материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг 2023 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 16:00 цагаас өмнө “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн доорх хаягаар дугтуйлж, тухайн оролцож буй тендерийн дугаарыг тэмдэглэж, битүүмжилсэн байдлаар ирүүлнэ.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сити Тауэр Бизнес төвийн 10 давхар, 1004 тоотод хүлээн авна. Төслийн ажилтан Д.Содчимэг. Цахим шуудан: [sodchimeg@nomad-systems.mn](mailto:sodchimeg@nomad-systems.mn) Утас: 99260010.

Үнийн саналын нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 16:05 цагт нээнэ.

ТӨСЛИЙН ЗОХИЦУУЛАГЧ



Д.АВИРМЭД

0000011303

**ХАРЬЦУУЛАЛТЫН АРГААР АЖИЛ ХУДАЛДАН АВАХ  
САНАЛ АВАХ ХҮСЭЛТ (АСАХ)**

- Төслийн нэр:** “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн “Дэд төвийг хөгжүүлэх институт, чадавхийг бий болгох зөвлөх үйлчилгээ /ТЗ-С01/” дэд төсөл
- Санхүүжилтийн эх үүсвэр:** Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл
- Гэрээний дугаар ба нэр:** ТЗ-SCS-03: Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ны эзэмшлийн 814-р байрны “Иргэдэд мэдээлэх төв”-ийн засвар шинэчлэлтийн ажил
- Хүсэлтийг гаргасан огноо:** 2023 оны 8 дугаар сарын 29-ний өдөр

Эрхэм хүндэт ..... таныг

1. “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл (цаашид “Захиалагч” гэх) дараах ажлыг гүйцэтгэх санал ирүүлэхийг үүгээр хүсэж байна:

№	Ажлын нэр	Хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Нийслэлийн орон сууцны корпораци ХК-ийн эзэмшлийн 814-р байрны “Иргэдэд мэдээлэх төв”-ийн засвар шинэчлэлтийн ажил	Гурван жижиг өрөө, нэг ариун цэврийн өрөө бүхий 187 м2 талбайтай байр	багц	1

Хэрэв та энэхүү худалдан авах ажиллагааны гэрээний зураг төсөл, техникийн тодорхойлолтыг бэлтгэсэн, эсхүл төслийг бэлтгэхэд оролцсон компани, эсвэл ажлыг хянах үүрэг гүйцэтгэх компанитай хамтран оролцож байгаа бол таны саналаас татгалзана.

Танд үнийн санал бэлтгэхэд туслах зорилгоор шаардлагатай үзүүлэлт, ажлын тоо хэмжээ, зураг, санал ирүүлэх маягт, болон гэрээний маягыг хавсаргав. Санал бэлтгэхийн тулд та өөрийн зардлаар ажлын талбайтай танилцаж, холбогдох мэдээллийг авч болно.

2. Та үнийн саналын эх хувийг саналын маягтын хамт ирүүлнэ.

3. Хавсралтад өгөгдсөн маягтын дагуу бэлтгэсэн таны санал нь гарын үсэг зурагдаж, дугтуйнд хийж битүүмжлэгдэн, хаяглагдсан байх ёстой бөгөөд дараах хаягт хандан илгээнэ:

**Захиалагчийн хаяг:** “Дэд төвийг хөгжүүлэх институт, чадавхийг бий болгох зөвлөх үйлчилгээ /ТЗ-С01/” дэд төсөл, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сити Тауэр Бизнес төвийн 10 давхар, 1004 тоот. Утас: 99260010

4. Та сүүлийн 3 жилд (2020, 2021, 2022) агуулга ба иж бүрдлийн хувьд энэ санал авах хүсэлтэд дурдсан ажилтай дүйцэхүйц, гурваас доошгүй ажлыг хийсэн үндсэн гүйцэтгэгчийн туршлагатай, мөн тухайн ажлыг гүйцэтгэж дуусгасан байх бөгөөд үүнийг батлах гэрээний

хуулбар болон ажил хүлээлцсэн дүгнэлтийн хамт ирүүлнэ (Хавсралт 1(а)-ийн МАЯГТ 1-ийг бөглөнө үү). Шаардлага хангаагүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзахгүй болохыг анхаарна уу.

5. Энэ ажлыг амжилттай хэрэгжүүлж дуусгахад шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, зээлжих эрхийн тодорхойлолт мөн бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ нь **105,000,000.00 (нэг зуун таван сая) төгрөг** байна. (Хавсралт 1(б)-ийн МАЯГТ 2-ыг бөглөнө үү). Шаардлага хангаагүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзахгүй болохыг анхаарна уу.

6. Та зөвхөн нэг саналыг ирүүлнэ. Та саналаа арилдаггүй бэхээр бичих ёстой бөгөөд та эсвэл таны эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж баталгаажуулна. Таны саналын маягт гарын үсэггүй тохиолдолд, таны саналыг цаашид үнэлгээнд харгалзахгүй.

7. Захиалагч саналуудыг үнэлэхдээ, тооцооллын алдааг дараах байдлаар залруулна:

- (а) тоогоор болон үгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрүүтэй бол үгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзэх;
- (б) үнэлэгдсэн ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ)-д заасан нийт үнэ ба саналын маягтад заасан үнийн хооронд зөрүүтэй бол үнэлэгдсэн ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ) дэх нийт үнийг баримтлах;
- (в) нэгж үнийг тоо хэмжээгээр үржүүлсэнтэй холбоотойгоор нэгж үнэ ба нийт үнийн хооронд зөрүүтэй бол нэгж үнийг баримтлах; ба
- (г) гүйцэтгэгч залруулгыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал, түүний саналаас татгалзана

8. Таны үнийн санал 2023 оны 9 дүгээр сарын 11-ний 16:00 цагаас хойш 60 өдрийн хугацаанд хүчинтэй байна

9. Монгол хэл дээр үйлдэгдсэн таны санал нь нийт ажлыг хамарсан байх ба **ирүүлсэн ажлын тоо хэмжээнд дурдсан нэгж ба нийт үнэ**-д үндэслэгдсэн байна. Санал болгосон үнэ ба төлбөрийг **төгрөг-өөр** гүйцэтгэнэ. Саналд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийн төлөх бүх гаалийн татвар, дотоодын татвар ба бусад хураамжийг тусгаж оруулна. Санал болгосон үнээс гадна, үнэлэгдсэн үнэд Монгол улсад мөрдөж байгаа нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)-ыг тусад нь тодорхой салгаж оруулна.

“Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөл нь Сангийн яамны НӨАТ-аас чөлөөлөгдсөн байгууллагуудын жагсаалтад багтсан ба Захиалагчаас барааны үнийг төлбөрийг шилжүүлэхдээ НӨАТ-гүй дүнгээр тооцож хийнэ.

10. Захиалагч гэрээний эрхийг энэхүү санал авах хүсэлтийн үндсэн шаардлагыг хангаж байгаа санал, түүнчлэн хамгийн сайн үнэлэгдсэн үнийн санал ирүүлсэн гүйцэтгэгчид олгоно. Хэрэв тухайн санал нь том зөрүү агуулсан, эсвэл санал авах хүсэлтэд заасан нөхцөл, шаардлага, тодорхойлолтын хувьд болзолт нөхцөлийг шаардсан бол ийм саналыг шаардлагад нийцэхгүй гэж үзэх ба түүнийг цаашид үнэлгээнд харгалзахгүй. Захиалагч зөвхөн шаардлагад нийцсэн саналуудыг үнэлж харьцуулна.

11. Хэрэв та тендерийн хүчинтэй хугацаанд өөрийн саналаа буцааж авах ба/эсвэл гэрээний эрх олгогдсон байхад гэрээний эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзвал таныг хоёр жилийн хугацаанд тухайн төслийн гүйцэтгэгчдийн жагсаалтаас хасна.

12. Гэрээний маягтад хавсаргасан нөхцөл ба шаардлагын дагуу энэ гэрээг хэрэгжүүлнэ.

13. Та саналаа саналын маягт болон 2 дугаар хэсэгт байгаа ажлын тоо хэмжээний дагуу бөглөсөн үнийн хамт 2023 оны 9 дүгээр сарын 11-ний 16:00 цагаас өмнө ирүүлнэ. Саналуудыг 2023 оны 9 дүгээр сарын 11-ний өдрийн 16:05 цагт дараах хаяг бүхий газарт нийтийн өмнө буюу оролцох хүсэлтэй байгаа санал ирүүлсэн тендерт оролцогчдын төлөөллийг байлцуулан нээнэ.

**Хаяг: “Дэд төвийг хөгжүүлэх институц, чадавхийг бий болгох зөвлөх үйлчилгээ /ТЗ-CS01/” дэд төсөл, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Сити Тауэр Бизнес төвийн 10 давхар, 1004 тоот**

Захиалагч санал ирүүлэх хугацаанаас хойш 60 өдрийн дотор санал нь хүлээн зөвшөөрөгдсөн тендерт оролцогчид зөвшөөрлийн захидлыг илгээж, гэрээний эрх олгосон тухай мэдэгдэнэ.

14. Захиалагч нь энэхүү санал авах хүсэлтийн үр дүнд худалдан авах ажлын төлбөрт Азийн хөгжлийн банк (АХБ) -ны хөнгөлөлттэй зээлийн санхүүжилтийн эх үүсвэрийг хэрэглэнэ.

15. АХБ-ны авлигын эсрэг бодлого, ёс зүйн хэм хэмжээний дагуу, тендерт оролцогч худалдан авах ажиллагаа болон түүнээс үүдэн гарах гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг сахина. Хэрэв гэрээний эрх авсан тендерт оролцогч эсвэл аливаа бусад этгээд тендерт өрсөлдөх эсвэл гэрээг хэрэгжүүлэх үед авлигал, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах эсвэл дарамт шахалт үзүүлэх үйлдэлд оролцсон нь тогтоогдвол АХБ гэрээний эрх олгох саналаас татгалзаж, үүнд холбогдсон талуудад хориг тогтооно. Саналаа ирүүлэх тэр мөчид, та АХБ-ны хориг жагсаалтад ороогүй байвал зохино. АХБ-ны авлигын эсрэг бодлого, ёс зүйн хэм хэмжээг Хавсралт 2-оос харна уу.

16. Та энэхүү хүсэлтийг авсан тухай болон үнийн санал ирүүлэх эсэхээ [sodchimeg@nomad-systems.mn](mailto:sodchimeg@nomad-systems.mn) цахим шуудангаар мэдэгдэнэ үү

Хүндэтгэсэн,

Д.Авирмэд, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн зохицуулагч

## САНАЛЫН МАЯГТ

\_\_\_\_\_ (Огноо)

Хэнд: \_\_\_\_\_ (Захиалагчийн нэр)

\_\_\_\_\_ (Захиалагчийн хаяг)

\_\_\_\_\_

Бид \_\_\_\_\_ (гэрээний нэр ба дугаар)-г (гэрээний маягтад заасан) гэрээний нөхцөлийн дагуу \_\_\_\_\_ (үнийн дүнг үсэг ба тоогоор илэрхийлэх) \_\_\_\_\_ (мөнгөн тэмдэгтийн нэр) бүхий гэрээний үнэтэй энэхүү саналын дагуу хэрэгжүүлэхээр санал болгож байна. Бид гэрээнд дурдсан ажлыг гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш \_\_\_\_\_ сарын дотор багтаан дуусгах саналтай байна.

Энэ санал болон таны бичгээр үйлдсэн зөвшөөрөл нь бидний хооронд байгуулах гэрээний хэсэг байх болно. Хамгийн сайн гэж үнэлэгдсэн тендер болон бусад хүлээн авсан тендерийг та хүлээн зөвшөөрөх үүрэг хүлээгээгүй гэдгийг бид ойлгож байна.

Энэ санал нь саналын баримт бичигт шаардсан саналын хүчинтэй хугацаатай нийцэж байгааг бид үүгээр баталгаажуулж байна.

Бид энэхүү санал авах хүсэлттэй уялдсан гэрээний зураг төсөл, тодорхойлолтыг бэлтгэсэн компанитай хамтран оролцоогүй болно.

Бид АХБ-ны хориг жагсаалтад ороогүй болно.

Эрх бүхий гарын үсэг: \_\_\_\_\_

Гарын үсэг зурах этгээдийн нэр ба албан тушаал: \_\_\_\_\_

Гүйцэтгэгчийн нэр: \_\_\_\_\_

Хаяг: \_\_\_\_\_

Утасны дугаар: \_\_\_\_\_

Факсын дугаар (шаардлагатай бол): \_\_\_\_\_

Цахим шуудан хаяг (шаардлагатай бол): \_\_\_\_\_

## 1 ДҮГЭЭР ХЭСЭГ – ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Материал	Тодорхойлолт	Тайлбар
1	Цонх	1460x1200мм хэмжээтэй - 5 ширхэг, 1760x1200мм хэмжээтэй -1 ширхэг цонх тус тус хийнэ. Эдгээр цонх нь стандарт бус хэмжээтэй тул захиалгаар хийлгэнэ. Цонх нь 3 давхар шилтэй MNS 5830:2007 стандартын дагуу, 2 давхар резинтэй, шил хооронд дулаан алдагдлыг багасгах аргон хий шахсан байна.	MNS 5830:2007 стандартыг хангасан 3 давхар шилтэй, металл рамтай 2 давхар резинтэй вакум цонх байна. Цонхыг угсрахдаа MNS 6266:2011 Барилгын хана, цонхны уулзварын угсралтын заадал. Техникийн ерөнхий шаардлага дагуу гүйцэтгэнэ.
2	Хаалга	900x2000мм хэмжээтэй цэвэр модон бүтэцтэй, гадна талаараа цагаан өнгийн хуулгаар бүрсэн байна.	Ариун цэврийн өрөөний хаалга нь MNS 531:2002 Барилгын модон хаалга, цонх, тагтны хаалга, техникийн ерөнхий шаардлага хангасан байна. Хаалгыг суулгахдаа MNS 6266:2011 Барилгын хана, цонхны уулзварын угсралтын заадал. Техникийн ерөнхий шаардлага дагуу гүйцэтгэнэ.
3	Дрож	Хурлын заал, амралтын өрөө, оффисын өрөөний шал нь чулуун шал байна. Чулуун шалыг хийхдээ одоо байгаа шал, шалны доор байгаа суурийг хуулж авна. Шалны гадаргууг тэгшлэх зорилгоор цементэн тэгшилгээ хийнэ. Үүн дээр багсармалаар шалны чулууг наана. Үүний дараа дрожийг дэвсэнэ.	Шалны ажлыг гүйцэтгэхдээ БНБД 31-09-05 "Шалны ажил" дүрмийг баримтлан суурийг бэлтгэн, тухайн өрөөний шалыг хийж гүйцэтгэнэ.
4	Чулуун плита	Ариун цэврийн өрөөний шал нь чулуун плита байна.Чулуун плитаг наахдаа одоо байгаа плитаг хуулан авч, гадаргууг цэвэрлэн 50-100мм зузаантай багсармалаар чулуун плитаг наана.	
5	Чулуун шал	Хүлээн авах үүдний хэсгийн шал нь чулуун шал байна. Чулуун шалыг хийхдээ одоо байгаа шал, шалны доор байгаа суурийг хуулж авна. Шалны гадаргууг тэгшлэх зорилгоор цементэн тэгшилгээ хийнэ. Үүн дээр 50-100мм багсармалаар шалны чулууг наана.	
6	Өрөөний тусгаарлах шилэн хана, хаалга	Хурлын заал, амралтын өрөөг тусгаарлах, хурлын зааланд нарны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх зорилгоор шилэн хана, хаалга төлөвлөв. Шилэн хаалга, хана нь металл рамтай, 2 давхар хатаасан шилтэй байна.	Шилэн хана нь MNS 5830:2007 стандартыг хангасан бүтэцтэй байх ба угсрахдаа MNS 6266:2011 "Барилгын хана, цонхны уулзварын угсралтын заадал. Техникийн ерөнхий шаардлага"-ын дагуу гүйцэтгэнэ.
7	Ариун	Дотор сантехникийн ажил гүйцэтгэхэд	Ариун цэврийн өрөөний

	цэврийн өрөөний тоноглол	хамтад нь гүйцэтгэх боломжтой. Бохир, цэвэр усны хоолойн гаргалгааг гаргаж тоноглол холбоход бэлэн болгоно. Ариун цэврийн өрөө нь эрэгтэй, эмэгтэй байх ба өрөө тус бүрд угаалтуур, суултуур байна.	тоноглол болох суултуур, угаалтуур зэргийг суурилуулахдаа БНБД 40-06-16 "Дотор сантехникийн систем"-ийн дагуу суурь бэлтгэлийг хийн гүйцэтгэнэ.
8	Тааз	Ариун цэврийн өрөөнөөс бусад өрөөний таазыг эмульсдэнэ. Эмульс хийхдээ одоо байгаа таазны эмульсийг хусаж арилган, гадаргууг цэвэрлэнэ. Үүн дээр хар замаск татаж гадаргууг тэгшилнэ NR7002 /шаргал/ өнгийн эмульсээр таазыг эмульсдэнэ. Ариун цэврийн өрөөний таазыг гипсэн хавтангаар хийнэ. Гипсэн таазны С хэлбэрийн хөнгөн рамаар хайрцаглан бэлдэнэ. Үүн дээр гипсэн хавтанг холбоно.	
9	Хана	Одоо байгаа ханын эмульсийг хусаж арилгана, гадаргууг цэвэрлэнэ. Үүний дараа хар замаскаар ханын гадаргууг тэгшлэн, шинээр хийнэ.	
10	Гоёлын хана	Гоёлын хана нь 1.8мм-ээс багагүй зузаантай байх ба физик, химийн шинж чанар сайтай, удаан эдэлгээтэй, байгаль орчинд ээлтэй, галд тэсвэртэй, цэвэрлэхэд хялбар, ус чийгт тэсвэртэй хавтан, материал ашиглана.	
11	Гэрэлтүүлэг	Ариун цэврийн өрөөнөөс бусад өрөөний гэрэлтүүлэг нь таазнаас бэхлэгдэнэ. Гэрэлтүүлэг нь таазнаас доош 300-350 мм урттай буусан байна. Ариун цэврийн өрөөнд нүдэн гэрэл байрлуулах ба шинээр хийгдэх гипсэн таазанд шууд суурилагдана. Суурилагдах нүх болон, холболтын утсыг гипсэн таазыг гүйцэтгэж байх үед хийнэ.	
12	Хяналтын камер, холбоо дохиоллын систем	Хэрэглэгчийн кабель шугамыг шалны бэлтгэлд 22мм, дохиоллын системийн кабелийг 16мм-ийн диаметртэй хуванцар хоолойд далд суурилуулна. Мэдээлэл, холбооны сүлжээний самбарын хэрэглэгчийн шугамын төгсгөлийн үүрийг хананд далд суурилуулна Холбоо дохиоллын системийн тоног төхөөрөмжийн тэжээлийн хангамжид зориулан Дамжуулан хуваарилах самбарт хамгийн ойрхон байгаа самбараас цахилгааны тэжээлийн	

		<p>кабель татаж 1 разетка суурилуулна. Хяналтын камер нь доорх техникийн үзүүлэлтийг хангасан өдөр шөнийн тусгалтай, ус чийгийн хамгаалалттай дотор байрлах IP камер байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Нягтрал: 2мегаpixel</li> <li>• Линз: 2.8мм</li> <li>• Харах өнцөг: 95 градус</li> <li>• Шөнийн тусгал: 20метр</li> <li>• Бичлэгийн өргөтгөл: H264, H265+</li> <li>• POE дэмждэг</li> </ul>	
13	Халуун хүйтэн ус, Ариутгах татуургын шугам хоолой	<p>Бохир усны хоолойг пласстмасан /PVC-U/ хоолойгоор угсарна. Ариун цэврийн хэрэгсэлд ус өгөх ба бохир ус гаргах цэгийн холболт өндрийн түвшнийг нийлүүлэх төхөөрөмжийн техникийн үзүүлэлттэй уялдуулан тохируулж гүйцэтгэнэ. Цэвэр усны шугамыг цайрдсан ган хоолойгоор дамжуулан түгээнэ. Ариун цэврийн хэрэгслүүдэд ус өгөх салбар хоолойн /подводок/ голч ф15мм-ээс багагүй байх ба пластмассан / PPR / хоолойгоор хийнэ.</p>	
14	Халаалт, агаар сэлгэлтийн шугам хоолой	<p>Одоо байгаа халаах хэрэгслийг секцен радиатораар солино. Шугам хоолойг угсарч дууссаны дараа БНБД40-06-16-ын дагуу 0.8 МПа-с ихгүй даралттай усаар шахаж шалгана. Агаар сэлгэлтийн системийг төлөвлөхдөө норм дүрмийн дагуу ердийн болон соролттой механик системээр зохион байгуулна. Агаар дамжуулах хоолойг цайрдсан ган хуудсан төмөр хоолойгоор, хана огтлолцох хэсгийн нүх зай бүрийг битүүмжилж, бетон зуурмагаар цутгана.</p>	<p>Халаалт, агаар сэлгэлтийн угсралтын ажлыг БНБД 12-03-04 Барилга үйлдвэрлэлийн хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм, БНБД 12-101-05 Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгаалалтын үлгэрчилсэн дүрмийн холбогдох заалтыг мөрдлөг болгон БНБД 40-06-16 Дотор сантехникийн системийн угсралтын дагуу тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай.</p>
15	Гараар угсарч хийх тавилга	<p>Гал тогооны тавилга, амрах хэсгийн ханын шүүгээ, ажилчдын өрөөний оффис бичгийн шүүгээ, ресейпшний ширээ, үүдний хувцасны шүүгээ, индэр, заалны бичгийн шүүгээ, амралтын өрөөний номын тавиур зэргийг тухайн байранд зориулан гараар угсарч хийнэ. Гараар угсарч хийх тавилгыг ус чийгт тэсвэртэй хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, угааж цэвэрлэхэд хялбар <b>Kronospan</b> хавтангаар хийнэ.</p>	



16	Худалдаж авах тоног төхөөрөмж	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Зурагт:</b> 85 инч, QLED дэлгэцтэй, 3840x2160 UltraHD нягтралтай, Airplay/Bluetooth/Cast screen холболт, HDMI - 4/USB – 2 оролттой.</li> <li>• <b>Лед дэлгэц:</b> 59 инч, 4K UHD Interactive Touch Display, i5, 8th Gen, 16GB, 256GB</li> <li>• <b>Хөргөгч:</b> 159 литр, нэг хаалгатай, жигд, түргэн хөлдөөдөг</li> <li>• <b>Богино долгионы зуух:</b> 23 литр, 800-1250 ватт</li> </ul>	
20	Худалдаж авах тавилга	<ul style="list-style-type: none"> <li>• <b>Оффис сандал:</b> Том хүний, дугуйтай сандал, их бие хар хөх, түшлэг саарал, суудал саарал өнгөтэй, нурууны түшлэг торон, толгойн түшлэг болон суудал даавуун материалтай, өндөр нягтралтай порлонтой, BJ-AL350-2 arolished aluminum base, дугуйн материал PP хуванцар, PU castor 60/25mm, өндөр намын тохируулгатай</li> <li>• <b>Оффис сандал (энгийн):</b> Их бие болон түшлэг арьсан материалтай, дугуйтай, хар сандал</li> <li>• <b>Хурлын өрөөний сандал:</b> PP сайжруулсан нурууны түшлэгтэй, өндөр нягтралтай суудлын зөөлөвчтэй, дугуйтай, эвхдэг, цагаан сандал</li> <li>• <b>Хурлын өрөөний ширээ:</b> 8 хүний</li> <li>• <b>Үүдний хүлээлгийн сандал:</b> Саарал өнгийн, модерн хийцтэй, метал хөлтэй, их бие цэвэр арьс, өндөр нягтаршилтай порлон, зиг заг пүрштэй</li> <li>• <b>Хооллох хэсгийн сандал:</b> Гүйцэтгэлийн явцад захиалагчтай зөвшилцөх</li> <li>• <b>Хооллох хэсгийн ширээ:</b> Гүйцэтгэлийн явцад захиалагчтай зөвшилцөнө</li> <li>• <b>Амрах хэсгийн буйдан:</b> Саарал өнгийн, модерн хийцтэй, метал хөлтэй, их бие цэвэр арьс, өндөр нягтаршилтай порлон, зиг заг пүрштэй, хөл амраагчтай</li> <li>• <b>Амрах хэсгийн дугуй сандал:</b> Саарал өнгийн, хуванцар их бие, төмөр хөлтэй</li> <li>• <b>Амрах хэсгийн ширээ:</b></li> </ul>	

		<p>Гүйцэтгэлийн явцад захиалагчтай зөвшилцөнө</p> <ul style="list-style-type: none"> <li>• <b>Ресейпшний сандал:</b> Гүйцэтгэлийн явцад захиалагчтай зөвшилцөнө</li> <li>• <b>Үүдний локер:</b> Хар хүрээ бүхий цагаан өнгийн нүүртэй, бүх хаалга 2 хувь түлхүүртэй</li> </ul>	
--	--	--	--

### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд тавигдах шаардлагууд**

Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй ХАБЭА-тай холбоотой хууль, тогтоомж, БНБД, стандарт, дүрэм, журмын дагуу хийж гүйцэтгэнэ.

Гүйцэтгэгч нь аливаа эрсдэл, эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, бууруулах бүхий л арга хэмжээг авч, аюулгүй болгосон байна.

Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана.

Энэхүү бүлэгт заасан ХАБЭА шаардлагыг хангах бүхий л арга хэмжээг авах зардлыг гэрээнд тухайлан зааж өгөөгүй тохиолдолд гэрээнд гүйцэтгэгчийн үнийн санал өгсөн бусад ажлуудын нэгж үнэнд шингэсэн гэж үзнэ.

Машин механизм, тоног төхөөрөмжийг зураг төслийн дагуу угсарч, суурилуулсан акт үйлдэж, аюулгүй ажиллагааны заавартай байна. Машин механизм, тоног төхөөрөмжийн хоорондын зай, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байна.

Гүйцэтгэгч нь бараа материал, тоног төхөөрөмжийн ачилт, тээвэрлэлт, буулгалт, хураалт, хадгалалтыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн осол аваараас урьдчилан сэргийлж ажилласан байна

Ачааг өргөхөд ашиглаж буй оосор нь даацын бат бэхийн гэрчилгээтэй, ямар нэгэн гэмтэлгүй байна. Ачааг өргөх, буулгах, зөөхөд оосорлогч, дохиочныг талбайд заавал байрлуулж, түүний дохиогоор ажлыг хийж гүйцэтгэнэ.

Өргөх, зөөх авто хэрэгслийн техникийн аюулгүй байдал хариуцсан ажилтныг тушаалаар томилж, ажлын талбайд байнгын ажиллуулсан байна.

Ажлын талбайн эмх цэгцийг бүрэн хангуулж ажиллах ба барилгын талбайн цэвэрлэгээ, хог ачилтыг гүйцэтгэж, зөвшөөрөгдсөн хогийн цэгт хаяж энэ талаар байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тусгасан байна. Шаардлагатай тохиолдолд цаг тухай бүрд нь цэвэрлэж, ачсан байна.

Гүйцэтгэгч нь барилгын талбайд болсон осол гэмтэл, анхны тусламж, эд хөрөнгийн элэгдэл хорогдол, эвдрэл гэмтлийн бүртгэл хөтөлж тайлан гаргана.

Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг нэн даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, ажлын талбайг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.

Гүйцэтгэгч нь төслийн талбайд ажиллах ажилтан бүрийг улирлын онцлогт тохирсон ажлын хувцас болон нэг бүрийн хамгаалах хэрэгслээр бүрэн хангах үүргийг хүлээнэ. Төслийн талбайд ажиллаж буй нийт ажилчид нэг бүрийн хамгаалах хэрэгслийг заавар зориулалтын дагуу

тогтмол, зөв хэрэглэх шаардлагатай. Төслийн талбайд түр хугацаагаар нэвтрэх зочид хамгаалалтын дуулга болон хантааз заавал өмсөнө. Төслийн талбайд заавал хэрэглэх шаардлагатай хувийн хамгаалах хэрэгслүүдэд Хүснэгт 1-т үзүүлсэн хэрэгслүүд хамаарна. Хувийн хамгаалах хэрэгслүүд нь MNS ISO 13688:2000 стандарт шаардлагыг хангасан байна.

<b>Хувийн хамгаалах хэрэгслүүд</b>	Хэрэглэх давтамж	Зураг
Гэрэл ойлгогч бүхий хамгаалалтын хувцас	Төслийн талбайд байнгын өмсөж хэрэглэнэ.	
Нүд ба нүүр хамгаалах хэрэгсэл	Гагнуурын болон тастаж авах тайрах ажил гүйцэтгэхдээ нүүр хамгаалах хэрэгсэл хэрэглэнэ. Бусад тохиолдолд нүдний шил байнгын хэрэглэнэ.	
Хөл хамгаалах хэрэгсэл	Төслийн талбайд байнгын өмсөж хэрэглэнэ	
Дуулга, малгай	Төслийн талбайд байнгын өмсөж хэрэглэнэ	
Гар хамгаалах хэрэгсэл	Төслийн талбайд байнгын өмсөж хэрэглэнэ	
Сонсгол хамгаалах хэрэгсэл	Дуу чимээ ихтэй орчинд хэрэглэнэ.	
Уналтаас хамгаалах хэрэгсэл	1.5метрээс дээш өндөрт байнгын ажлын шат тавцангүй орчинд хэрэглэнэ.	
Амьсгалын эрхтэн хамгаалах хэрэгсэл	Тоос шороо ихтэй орчинд хэрэглэнэ.	

## 2 ДУГААР ХЭСЭГ – АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж өртөг /Төгрөг/	Бүгд өртөг /Төгрөг/
<b>1. БУУЛГАХ АЖЛУУД</b>					
1.1	Хуучин будагтай таазны гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м <sup>2</sup>	190		
1.2	Хуучин будагтай ханын гадаргууг 100% хусаж цэвэрлэх	м <sup>2</sup>	364		
1.3	Тавиуртай цонхыг задалж буулгах	м <sup>2</sup>	13.5		
1.4	Хаалга буулгах	хайрцаг	5		
1.5	120мм зузаан тоосгон хана буулгах	м <sup>3</sup>	3.2		
1.6	Вааран хавтанцраар хийсэн ханын өнгөлгөөг буулгах	м <sup>2</sup>	32		
1.7	Бетон дэвсгэр үетэй цементэн шалыг хийн алхаар ухаж задалж буулгах	м <sup>2</sup>	85		
1.8	Унтраалга, разетка, гэрэлтүүлэг буулгах	100ш	0.1		
1.9	Шаазан жорлон буулгах	ш	1		
1.1	Хананд цахилгааны монтажийн хоолой тавих ховил ухах	м	46		
1.11	Тоосгон хананд унтраалга разетка суулгах 100мм хүртэл гүн нүх гаргах	1 нүх	22		
1.12	Өрөө тасалгааны хог цэвэрлэх	м <sup>2</sup>	89		
<b>Бүлгийн дүн 1</b>					
<b>2. ХАНА, ХАМАР ХАНЫН АЖИЛ</b>					
2.1	Цонхны нүх проёмыг 360 мм-ийн өргөн ханыг хийжсэн сийрмэг гулдмайгаар битүүлж өрөх	м <sup>3</sup>	0.9		
2.2	Тоосгон хамар хана өрөх	м <sup>2</sup>	31.4		
2.3	Ханын шүүгээ ба антерсолийн хана хийх	м <sup>2</sup>	34.2		
2.4	Ханын шүүгээ ба антерсолийн тавиур хийх	м <sup>2</sup>	21.6		
2.5	Ханын шүүгээний хаалга угсрах	ш	6		
2.6	Антерсолийн хаалга угсрах	ш	6		
2.7	Ширээ, шүүгээ, угаалгын ба хөргөх шүүгээ зэрэг ширхгийн эдлэлүүд угсрах	ш	18		
<b>Бүлгийн дүн 2</b>					

<b>3. ХААЛГА, ЦОНХНЫ АЖИЛ</b>					
3.1	Вакум цонх суулгах	м <sup>2</sup>	13.5		
3.2	Цонхны зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжиж дулаалах	м <sup>2</sup>	13.5		
3.3	Дотор хананд хээтэй, 1 самбартай модон хаалга суулгах	м <sup>2</sup>	7.2		
3.4	Цонхонд өнгөлсөн гантиг тавиур суулгах	м <sup>2</sup>	3.15		
3.5	Модон хаалганд цоож суулгах	ш	5		
3.6	1 самбартай хаалганд хэрэглэл суулгах	ш	4		
3.7	3.6м <sup>2</sup> хүртэл талбайтай дулаалгатай төмөр хаалга суулгах, /электрон цоожтой/	ш	1		
3.8	Хаалганд хаалга тайвшруулагч угсрах	шр	2		
3.9	Гадна хананд металл рамтай вакум шилтэй хаалга суулгах	м <sup>2</sup>	16.2		
3.10	Дотор, гадна хананд суулгасан модон ба шилтэй хаалганы зай завсрыг баллонтой шүршдэг хөөсөөр чигжих	м <sup>2</sup>	9.45		
<b>Бүлгийн дүн 3</b>					
<b>4. ДОТОР ЗАСЛЫН АЖЛУУД</b>					
4.1	Тааз эмульсээр өндөр чанартай будах	м <sup>2</sup>	178		
4.2	Дотор хана цементэн зуурмагаар шавардах	м <sup>2</sup>	64		
4.3	Цахилгааны монтажийн дараах шаврын засвар хананд хийх	м <sup>2</sup>	11		
4.4	Дотор тоосгон хана цементэн зуурмагаар гараар сайн чанартай шавардах	м <sup>2</sup>	24		
4.5	Цонхны дотор амлагаа шавардах	м <sup>2</sup>	8.1		
4.6	200мм хүртэл өргөн амлагааг цементэн зуурмагаар шавардах	у/м	25		
4.7	Хананд гаргасан арк шахмал чулуун хавтангаар эмжээрлэн хүрээ хийх	м <sup>2</sup>	11.3		
4.8	Хананд тэгшилгээ хийх	м <sup>2</sup>	364		
4.9	Усан цийдмэгээр хана буун цацагчаар 90% багсаар 10% будах	м <sup>2</sup>	364		
4.10	Хана эмульсээр өндөр чанартай будах /өнгөний код/	м <sup>2</sup>	186		

4.11	50мм бага голчтой хоолойнууд будах	м <sup>2</sup>	12		
4.12	Хананд 300х600 мм-ийн өнгөлгөөний хавтанцар цавуугаар наах	м <sup>2</sup>	33		
4.13	Үнэр шингээгч түрхлэгийг нийтийн бие засах газрын хананд түрхэх	м <sup>2</sup>	3		
4.14	Шахмал чулуун хавтангаар хана өнгөлөх	м <sup>2</sup>	8.5		
4.15	WD-01 хананд хавтанцар өнгөлгөө хийх h=1.1m	м <sup>2</sup>	92		
4.16	Хананд 18мм зузаантай МДФ хавтангаар хэлбэржүүлсэн 70мм өргөнтэй чимэглэлийн модон хийц бэлтгэж угсрах	м <sup>2</sup>	154		
4.17	130х30мм огтлол бүхий металл рамтай, 1 хаалгатай, 1 камертай шилэн багц бүхий хана угсрах	м <sup>2</sup>	19.6		
4.18	Шилэн хана, хаалганд зураглал гарган хальсан хуулга наах	м <sup>2</sup>	13.7		
4.19	Шилэн хананд жалиузан хөшиг тавих	ш	7		
4.20	Угаалтуурын чулуун хавтан угсрах	м <sup>2</sup>	1.8		
4.21	Чийгтэй орчинд толийг хананд нааж суулгах	м <sup>2</sup>	1.8		
	<b>Бүлгийн дүн 4</b>				
<b>5. ШАЛНЫ АЖИЛ</b>					
5.1	50мм зузаан бетон тэгшилгээ хийх	м <sup>2</sup>	190		
5.2	Шалны бетон гадаргууд хар тосон хөрсжүүлэлт бт-577 маркийн лакаар хийх	м <sup>2</sup>	190		
5.3	20 мм зузаан цементэн тэгшилгээ хийх /б=30мм/	м <sup>2</sup>	190		
5.4	Цементэн тэгшилгээний зузааны өөрчлөгдөх 5мм тутамд нэмэх ба хасах	м <sup>2</sup>	380		
5.5	Шал тэгшлэгч хийх	м <sup>2</sup>	190		
5.6	Хавтанцрыг /плита/ бетон шаланд цавуугаар наах	м <sup>2</sup>	5.9		
5.7	Шахмал чулуун хавтан /гоёлын/ дэвсэж шал хийх	м <sup>2</sup>	49		
5.8	Хулдаасан хавтанцар өнгөлгөөг бетон шаланд наах	м <sup>2</sup>	21.4		
5.9	Хивсэнцэр хавтан бетон шаланд наах	м <sup>2</sup>	114		
5.10	Технологийн хөндий шал хийх	м <sup>2</sup>	21.4		

	<b>Бүлгийн дүн 5</b>				
<b>6. БУСАД ЗАСЛЫН АЖИЛ</b>					
6.1	Бетон зуурмаг бэлтгэх	м <sup>3</sup>	9.5		
6.2	Барилгын хог ялгаж овоолох ба автомашинд ачиж хаях	м <sup>3</sup>	4.6		
	<b>Бүлгийн дүн 6</b>				
<b>7. САЛХИВЧИЙН АЖИЛ</b>					
7.1	Хэвлэмэл ган радиатор угсрах KORADO RADIK C 21-05-10	ш			
7.2	Радиаторын хаалт тавих d= 15мм	ш			
7.3	Гадна блок байрлуулах Q = 5.6кВт	ком	1		
7.4	Кондиционер байрлуулах Q = 4.7/ 3.0 кВт	ком	1		
7.5	Кондиционер байрлуулах Q = 3.75 2.8 кВт	ком	1		
7.6	Хиншүү сорогч тавих	ш	1		
7.7	Агаарын клапан тавих	ш	3		
7.8	Сэнс угсрах Vortlce Lineo VO200	ш	1		
7.9	0.5 мм зузаан гөлмөн төмрөөр хийсэн агаар дамжуулах тэгш өнцөгт 200х200мм огтлолтой хоолой угсрах	м <sup>2</sup>	5.2		
7.10	Агаарын тэгш өнцөгт огтлолтой хоолойн гуравлагчийн бэлдэц хийж бэлтгэх, 200х200/150х150	ш	2		
7.11	Агаарын уян хоолой угсрах, ф150мм	м <sup>2</sup>	4		
7.12	Сараалж тавих ф150 МВ Пфс	ш	9		
	<b>Бүлгийн дүн 7</b>				
<b>8. ХАЛУУН, ХҮЙТЭН УС</b>					
8.1	Цайрдсан ган хоолой угсрах ф15мм	м	6		
8.2	Усан хангамжийн цайрдсан ган хоолойн бэлдэц бэлтгэх яндангийн голч-15мм	м	6		
8.3	Дотор ус хангамжийн хөнгөн цагаан голчтой хуванцар хоолой ф16 мм	м	12		
8.4	Хуванцар хоолойн холбох хэрэгсэл тавих ф15мм	ш	6		
8.5	Бөмбөлгөн хаалт тавих d= 20х1/2" PN1.0 2 талдаа шилжүүлэгтэй	ш	2		

8.6	Бөмбөлгөн хаалт тавих d= 15мм	ш	6		
8.7	Хүйтэн усны тоолуур байрлуулах d=15мм	ш	1		
8.8	Халуун усны тоолуур байрлуулах d=15мм	ш	1		
	<b>Бүлгийн дүн 8</b>				
<b>9. АРИУТГАХ ТАТУУРГА</b>					
9.1	Бохир усны хуванцар хоолой d=100 мм	м	5		
9.2	Бохир усны хуванцар хоолой d=50 мм	м	6		
9.3	Мойка тавих	ш	1		
9.4	Угаагуур тавих	ш	2		
9.5	Угаагуурын холигч тавих	ш	2		
9.6	Гал тогооны холигч байрлуулах	ш	1		
9.7	Усан хаалт тавих /мойк/	ш	3		
9.8	Суултуур байрлуулах	ком	2		
	<b>Бүлгийн дүн 9</b>				
<b>10. ДОТОР ГЭРЭЛТҮҮЛЭГ</b>					
10.1	Гэрэлтүүлгийн самбар угсрах ГС - 1. 1	ком	1		
10.2	Дүүжин таазанд тоноглох Лед гэрэлтүүлэгчтэй 24Вт 1740лм 4000К, 460x460x205мм IP20	ш	8		
10.3	Таазанд тоноглох Лед гэрэлтүүлэгчтэй 18Вт 2681лм 4000К, 295x295мм IP20	ш	2		
10.4	LInGBo - Truch spotlight - LSL 030001 загварын таазанд тавих замтай гэрэлтүүлэгч тоноглох 230В, IP-20	ш	8		
10.5	OPPLE - MZL 11136T - WH - 37W гэрэлтүүлэгчийг блокчлон дүүжинд угсрах	ш	31		
10.6	200Вт хүртэл чадалтай ЛЕД чийдэнтэй хананд тавих хамгаалагдсан гэрэлтүүлэгч IP-44	ш	2		
10.7	1x36Вт чадалтай өдрийн чийдэнтэй таазанд тавих ус чийгээс хамгаалагдсан гэрэлтүүлэгч IP-65	ш	2		
10.8	"ГАРАХ" бичигтэй хананд тоноглох 1x8Вт чадалтай цэнэглэгддэг хураагууртай гэрэлтүүлэгч угсрах, 230В, IP20	ш	1		



10.9	Солиур залгуур далд угсрах	ш	2		
10.10	Ердийн 1 туйлт унтраалга хананд тавих 230В, 16А, IP20	ш	2		
10.11	Ердийн 2 туйлт унтраалга хананд тавих 230В, 16А, IP20	ш	3		
10.12	Далд тоноглох газардуулагч контакттай хоёр туйлт ердийн разетка тавих, 250В, 10А, IP20	ш	12		
10.13	Утас салбарлах хайрцаг хананд суулгах /засав/	ш	8		
10.14	Ф16мм уян пластмассан хоолой тавих	м	245		
10.15	ППВ маркийн 1х2.5мм <sup>2</sup> хүртэл огтлолтой утас татах	м	650		
10.16	ППВ маркийн 1х4мм <sup>2</sup> хүртэл огтлолтой утас татах	м	180		
	<b>Бүлгийн дүн 10</b>				
<b>11. ГАЛЫН ДОХИОЛОЛ</b>					
11.1	Галын дохиолол хүлээн авах төхөөрөмж Сигнал-10	ком	1		
11.2	Галын дохиоллын утаа мэдрэгч угсрах ип212	ш	9		
11.3	Дуут дохио өгөгч угсрах	ш	1		
11.4	Галын дохиоллын гар мэдээлэгч ИПР-3	ш	1		
11.5	Зэс дамжуулагчтай полиэтилен тусгаарлагчтай сүлжээний зэс кабель utp 4х2х0.5	100 м	0.2		
11.6	Кабель татах КСРПнг (А)-FRHF 2х2х0.5мм <sup>2</sup>	100м	1.1		
11.7	Галын дохиоллын холболтын хайрцаг КС-4	ш	6		
11.8	Хуванцар уян хоолойг суурилуулах д16мм	м	0.8		
11.9	Галын хор /CO2/	ш	2		
	<b>Бүлгийн дүн 11</b>				
<b>12. КОМПЬЮТЕРЫН СҮЛЖЭЭ</b>					
12.1	Компьютерын сүлжээний салаалагч тавих свитч 24 порт, Swtch clscik s9200	ш	1		
12.2	Компьютерын сүлжээний салаалагч тавих свитч 8 порт, Swtch DH-PFS3110-8ET-96	ш	1		
12.3	Телефон, компьютерын хосолсон разетка хананд суурилуулах	ш	6		
12.4	Зэс дамжуулагчтай полиэтилен тусгаарлагчтай сүлжээний зэс кабель utp 4х2х0.5	100м	1.9		
12.5	Хуванцар уян хоолойг суурилуулах д16мм	м	1.6		

	<b>Бүлгийн дүн 12</b>			
<b>13. БУСАД</b>				
13.1	Гал тогооны тавилга (0.6м х 4м х 2.8м)	м <sup>2</sup>	11.2	
13.2	Амрах хэсгийн ханын шүүгээ (0.6м х 5.37м х 2.4м)	м <sup>2</sup>	12.888	
13.3	Ажилчдын өрөөний оффис бичгийн шүүгээ (0.6м х 2.2м х 2.5м)	м <sup>2</sup>	5.5	
13.4	Ресейпшний ширээ (1м х 3.9м х 1.2м)	м <sup>2</sup>	4.68	
13.5	Үүдний хувцасны шүүгээ (0.6м х 1.9м х 2.8м)	м <sup>2</sup>	5.32	
13.6	Индэр (1м х 1м х 1.4м)	м <sup>2</sup>	1.4	
13.7	Заалны бичгийн шүүгээ (0.7м х 0.8м х 2.8м)	м <sup>2</sup>	2.24	
13.8	Амралтын өрөөний номын тавиур (0.6м х 1.62м х 2.8м)	м <sup>2</sup>	1.536	
13.9	Зурагт (85 инч)	ш	2	
13.10	Лед дэлгэц (1.8м х 1.2м)	ш	1	
13.11	Оффис сандал (дугуй хөлтэй)	ш	2	
13.12	Оффис сандал (энгийн)	ш	8	
13.13	Хурлын өрөөний сандал	ш	30	
13.14	Хурлын өрөөний ширээ (1.5м х 2м х 0.9м)	ш	2	
13.15	Үүдний хүлээлгийн сандал	ш	2	
13.16	Хооллох хэсгийн сандал	ш	2	
13.17	Хооллох хэсгийн ширээ (1.2м х 1.2м)	ш	1	
13.18	Амрах хэсгийн буйдан (0.8м х 2м х 0.8м)	ш	2	
13.19	Амрах хэсгийн дугуй сандал	ш	2	
13.20	Амрах хэсгийн ширээ	ш	1	
13.21	Ресейпшний сандал	ш	1	
13.22	Үүдний локер	ш	10	
13.23	Хөргөгч (нэг хаалгатай)	ш	1	
13.24	Богино долгионы зуух	ш	1	
<b>Бүлгийн дүн 13</b>				
<b>Нийт дүн /НӨАТ-гүй/ /Бүлэг 1+Бүлэг 2+Бүлэг 3+Бүлэг 4+Бүлэг 5+Бүлэг 6+Бүлэг 7+Бүлэг 8+ Бүлэг 9+ Бүлэг 10+ Бүлэг 11+ Бүлэг 12+ Бүлэг 13/</b>				
<b>НӨАТ</b>				
<b>НӨАТ-тэй нийт дүн /НӨАТ-тэй/</b>				

### **3 ДУГААР ХЭСЭГ – ЗУРАГ ТӨСӨЛ**

Хавсралт 3-ыг харна уу

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

Улсын нэр: Монгол улс

Төслийн нэр: “Улаанбаатар хотын Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн “Дэд төвийг хөгжүүлэх институт, чадавхийг бий болгох зөвлөх үйлчилгээ /ТЗ-CS01/” дэд төсөл

Гэрээний нэр: \_\_\_\_\_

Гэрээний дугаар: \_\_\_\_\_

Энэ гэрээг 2023 \_\_\_\_ оны \_\_\_\_ дүгээр сарын \_\_\_\_-ний өдөр нэг талаас \_\_\_\_\_ (цаашид “захиалагч” гэх) ба нөгөө талаас \_\_\_\_\_ (цаашид “гүйцэтгэгч” гэх) нар байгуулав.

Захиалагч гүйцэтгэгчээс \_\_\_\_\_ (гэрээний нэр ба дугаар) бүхий ажил гүйцэтгэх санал ирүүлэхийг хүссэний дагуу гүйцэтгэгч дээрх ажлыг хийх саналаа ирүүлсэн, бөгөөд энэ ажлыг хийж дуусгах, аливаа гэмтэл согогийг арилгах тухай 2023 оны \_\_\_\_ дүгээр \_\_\_\_ сарын \_\_\_\_-ний өдрийн гүйцэтгэгчийн саналыг захиалагч хүлээн зөвшөөрсөн.

### ЭНЭХҮҮ ГЭРЭЭГЭЭР ДАРААХ ЗҮЙЛСИЙГ ГЭРЧИЛНЭ:

1. Гүйцэтгэгч энэхүү гэрээ (Хавсралт 1)-ний салшгүй хэсэг болох гүйцэтгэгчийн санал дахь ажлын хүснэгт (эсхүл ажлын тоо хэмжээ)-д дурдсан бүх ажлыг гэрээний дараах нөхцөл шаардлагын дагуу мэргэжлийн түвшинд чадвартайгаар хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

- a) Гэрээг хэрэгжүүлэх үед болон чанарын баталгаат хугацааны туршид гарах бүх гэмтэл согогийг, хариуцсан инженерээс мэдэгдэл авсан өдрөөс хойш \_\_\_\_ хоногийн дотор засаж арилгах;
- b) Гэрээний гүйцэтгэл хангалтгүй тохиолдолд захиалагч бичгээр мэдэгдсэнээс хойш \_\_\_\_ хоногийн дараа гэрээг цуцлах эрхтэй. Хэрэв гэрээ нь дайн, эсвэл захиалагч эсхүл гүйцэтгэгчийн хяналтаас үл хамаарах аливаа явдлаас болж хэрэгжээгүй тохиолдолд хариуцсан инженер нь гэрээ хэрэгжээгүй болохыг нотлох ёстой. Ийм тохиолдолд, захиалагч ба гүйцэтгэгч нар нөгөө талдаа санхүүгийн ямар нэгэн үр дагавар учруулахгүйгээр \_\_\_\_ хоногийн мэдэгдэл хүргэх замаар гэрээг цуцлах эрхтэй. Гэрээг цуцалсны дараа төлбөр хийхдээ, хийж дуусгасан ажил, нийлүүлж хүргэсэн барааны үнэ өртөг, болон урьдчилгаа төлбөр зэргийг харгалзана
- c) Хэрэв гүйцэтгэгчийн буруутай үйлдлээс болж гэрээг цуцалсан тохиолдолд, ажлын талбай дээр байгаа бүх материал, барилгын тоног төхөөрөмж, дуусаагүй болон дууссан ажил нь захиалагчийн өмч хөрөнгө болно;
- d) Гүйцэтгэгч бүх тохиолдолд хариуцсан инженерийн удирдамжийг баримтлан ажиллана;
- e) Гүйцэтгэгч хариуцсан инженерт гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш \_\_\_\_ хоногийн дотор ажлын хөтөлбөрийг гаргаж өгөх ба үүнд ажил хийж дуусгах ерөнхий арга зүй, хуваарийг тусгана;
- f) Гэрээг дуусгах хугацаа: Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш \_\_\_\_ хоног;
- g) Ажлын аль нэг хэсгийг захиалагчийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр туслан гүйцэтгэгчээр хийлгэхийг хориглоно;
- h) Хариуцсан инженерийн захиалгын дагуу, харилцан тохиролцсон нэгж үнийг үндэслэн шинээр гүйцэтгэсэн ажлыг төлнө. Хэрэв гүйцэтгэгч ба хариуцсан инженер харилцан тохиролцож чадахгүй тохиолдолд, хариуцсан инженерийн тогтоосон нэгж үнийг гүйцэтгэгч дагаж мөрдөнө;
- i) Гэрээний дагаж мөрдөх хууль нь \_\_\_\_\_ (захиалагчийн улс) улсын хууль тогтоомж байна;

- j) Гүйцэтгэгч ажлын талбайд явуулах бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна;
- k) Ажлыг гүйцэтгэх явцад, хариуцсан инженер, \_\_\_\_\_ (хариуцсан инженерийн нэрийг оруулах) талбай дээр ажлын гүйцэтгэлийг шалгах бөгөөд батлагдсан тодорхойлолтын дагуу, шаардсан чанарын хэмжээнд хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж нотолно. Хариуцсан инженер нь шаардсан тодорхойлолтын дагуу хийж гүйцэтгээгүй ажлаас татгалзах бөгөөд гүйцэтгэгч “а” дэд зүйлд заасны дагуу бүх гэмтэл согогийг засаж арилгах арга хэмжээг яаралтай авна;
- l) Урьдчилан тааварлах боломжгүй нөхцөл байдал, тухайлбал дайн, түүнчлэн газар хөдлөлт, үер, гал түймэр гэх мэт байгалийн гамшиг тохиолдсон бол аль ч тал нь нөгөө талдаа 21 өдрийн мэдэгдэл гаргах замаар гэрээг цуцалж болно. Ийм тохиолдолд төлбөрийг гэрээг цуцалсан өдрөөр тасалбар болгон гүйцэтгэнэ;
- m) Гүйцэтгэгч \_\_\_\_\_ (улсын нэр) улсын хууль тогтоомжийн дагуу бүх татвар, хураамж, ноогдлыг хариуцна; ба
- n) Захиалагч ба гүйцэтгэгч нь тэдгээрийн хооронд гэрээтэй холбогдон гарч болох аливаа үл тохиролцоо эсвэл маргааныг зөвшилцөн шийдвэрлэнэ. Маргааныг шийдвэрлэж чадахгүй тохиолдолд, аль нэг тал нь гэрээнд мөрдөх хууль тогтоомжийн дагуу уг маргааныг \_\_\_\_\_ (захиалагчийн улсын байгууллагын нэр, тухайлбал инженерүүдийн холбоо, хуулийн институт)-д шилжүүлнэ.

2. Дээрх зүйлсийг харгалзан, захиалагч нь гүйцэтгэгчид дараах нөхцөлийн дагуу \_\_\_\_\_ (үг ба тоогоор илэрхийлэх) бүхий гэрээний үнийг төлөх үүрэгтэй:

- (i) Гэрээний урьдчилгаа төлбөр хийгдэхгүй.
- (ii) Явцын 2 төлбөр тус бүрийг гэрээний үнийн \_\_ хувьтай тэнцэх хэмжээгээр хийнэ. Нэгж үнэ ба тоо хэмжээг үндэслэн тооцсон ажлын гүйцэтгэлийн хэмжээ гэрээний үнийн \_\_ хувьд хүрсэн тохиолдолд нэхэмжлэхийг ирүүлснээс \_\_ хоногт багтаан төлбөр бүрийг хийнэ.
- (iii) Хариуцсан инженер ажил дууссан эсэхийг хянаж баталгаажуулсны эцэст, гэрээний үнийн үлдэх \_\_ хувьтай тэнцэх эцсийн төлбөрийг хийнэ.

Хариуцсан инженерээр хянан баталгаажуулсан төлбөрийн хүсэлтийг гүйцэтгэгчээс ирүүлсэн өдрөөс хойш \_\_ хоногийн дотор дээрх төлбөрийг гүйцэтгэгчид хийнэ.

3. Чанарын баталгаат хугацаа нь дууссан ажлыг захиалагчаас хүлээн авснаас хойш 6 сар байна.

Талууд энэхүү гэрээг дээр дурдсан өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр үүгээр байгуулав.

**Захиалагчийн гарын үсэг ба тамга:**  
Захиалагчийг төлөөлж

**Гүйцэтгэгчийн гарын үсэг ба тамга:**  
Гүйцэтгэгчийг төлөөлж

\_\_\_\_\_  
Эрх бүхий төлөөлөгчийн нэр

\_\_\_\_\_  
Эрх бүхий төлөөлөгчийн нэр

## ЗӨВШӨӨРЛИЙН ЗАХИДАЛ

Огноо: \_\_\_\_\_

Хэнд: \_\_\_\_\_ [Гүйцэтгэгчийн нэр ба хаяг]

Эрхэм хүндэт \_\_\_\_\_ танаа,

Саналын хүсэлтийн дагуу залруулж өөрчилсөн \_\_\_\_\_ [гэрээний дугаар ба нэр] гэрээт ажлыг \_\_\_\_\_ [гэрээний үнийн дүнг үсэг ба тоогоор оруулах] үнийн дүнд багтаан хийж гүйцэтгэхээр ирүүлсэн таны саналыг бид хүлээн зөвшөөрч байгааг танд үүгээр мэдэгдэж байна.

Түүнээс гадна та хавсралтад байгаа гэрээний маягтад гарын үсэг зурж, ажлыг \_\_\_\_\_ өдрөөс хэтрүүлэхгүйгээр эхлүүлэхээс гадна гэрээнд заасан барилгын ажлын хугацаанд багтаан хийж дуусгааа баталгаажуулна уу.

Захиалагчийг төлөөлж:

Эрх бүхий гарын үсэг: \_\_\_\_\_

Гарын үсэг зурах этгээдийн нэр: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_

## Ижил төрлийн гэрээ гүйцэтгэсэн туршлага - Маягт 1

/Гэрээ тус бүрээр маягтыг бөглөнө/

Гэрээний дугаар: .....	Гэрээний нэр: .....
Гэрээ байгуулсан огноо: .....	Гэрээний нийт дүн: ..... төгрөг
Гэрээ дуусгавар болсон огноо: .....	
Хийгдсэн ажлуудын нэр төрөл, тоо ширхэг	- - - - -
Захиалагчийн нэр: Холбогдох хүн: Хаяг: Утас/Факс: Цахим хаяг:	

**Санхүүгийн чадавх - Маягт 2**

Энэ ажлыг гүйцэтгэхэд шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгө, зээлийн шугам, зээлжих эрхийн тодорхойлолт мөн бусад санхүүжилтийн эх үүсвэрийг (гэрээний урьдчилгаа төлбөр үүнд хамаарахгүй) олж авах эрхтэй, эсхүл авах боломжтой гэдгээ илтгэн мэдээлэх шаардлагатай. Шаардагдах түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн доод хэмжээ 105,000,000.00 (нэг зуун таван сая) төгрөг байна.

<b>Санхүүгийн эх үүсвэр</b>	<b>Дүн</b>
1.	
2.	
3.	
4.	



**АХБ-НЫ АВЛИГЫН ЭСРЭГ БОДЛОГО, ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ****Авлигын эсрэг бодлого**

АХБ-ны авлигын эсрэг бодлого нь зээлдэгчдийг (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгчид) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний зөвлөхүүдийг сонгон шалгаруулах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогод заасны дагуу, энэхүү зөвлөхийн журмын хүрээнд АХБ нь:

(а) Энэхүү заалтын хүрээнд дор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:

- (i) “авлигын үйлдэл” гэдэг нь бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд ямар нэг үнэ цэнтэй зүйлийг шууд эсвэл шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг;
  - (ii) “залилан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсвэл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор аливаа талыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;
  - (iii) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь аливаа талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа талд буюу түүний өмч хөрөнгөд шууд эсвэл шууд бусаар хохирол учруулах, эсвэл хохирол учруулахаар заналхийлэхийг;
  - (iv) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш талууд зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг тус тус хэлнэ.
  - (v) “шамшигдуулах” гэдэг нь АХБ-ны холбогдох үйл ажиллагаанд зориулсан хөрөнгийг санаатайгаар эсхүл болгоомжгүй байдлын улмаас хулгайлах, үрэгдүүлэх болон зүй бусаар ашиглахыг хэлнэ;
  - (vi) “сонирхлын зөрчил” гэдэг нь нэг тал нь нөгөө талын албан үүргээ гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь эсхүл холбогдох хууль тогтоомжийг мөрдөх явцад нь зүй бусаар нөлөөлж болзошгүй сонирхол агуулагдсан аливаа нөхцөл байдлыг хэлнэ;
  - (vii) “саад учруулах” гэдэг нь (а) АХБ-ны хяналт шалгалтын нотлох баримтыг санаатайгаар устгах, хуурамчаар үйлдэх, өөрчлөх болон нуун дарагдуулах, эсхүл АХБ-ны хяналт шалгалтад саад учруулахын тулд шалгагчдад санаатайгаар худал мэдүүлэг өгөх; (б) банкны хяналт шалгалттай холбогдсон мэдээллийг ил болгох эсхүл хяналт шалгалтыг явуулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор аль нэг талыг айлган сүрдүүлэх, дарамтлах, заналхийлэхийг;
  - (viii) “шударга байдлыг зөрчих” гэдэг нь АХБ-ны шударга байдлын зарчим ба журам (2015, цаашид нэмж өөрчлөх)-д заасан, АХБ-ны Авлигын эсрэг бодлого, мөн өмнөх (i)-(vii)-д болон дор дурдсан нөхцөлийг зөрчсөн аливаа үйлдэл; АХБ-ны авч хэрэгжүүлэх хориг арга хэмжээ, мэдээлэгч эсхүл гэрчийн эсрэг өшөө авах ажиллагаа болон АХБ-ны Авлигын эсрэг бодлого, ёс зүйн хэм хэмжээг баримтлаагүй зэрэг зөрчлүүдийг хэлнэ.
- (b) Гэрээний эрх олгохоор санал болгосон зөвлөх нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх үед шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол гэрээний эрх олгох саналыг үл зөвшөөрнө;
- (c) АХБ-аас санхүүжилт авсан зээлдэгчийн төлөөлөгч нь зөвлөхийг сонгон шалгаруулах, эсвэл гэрээг хэрэгжүүлэх явцад авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх,

эсвэл үгсэн хуйвалдах зэрэг үйлдэлд оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг хүчингүй болгоно;

- (d) Хэрэв компани ба хувь хүн шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол, ийм зөвлөх компани, хувь хүн болон түүний залгамжлагчийг тодорхой эсхүл тодорхойгүй хугацаагаар АХБ-аас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг арга хэмжээнд оролцох, эсвэл АХБ-аас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны авлигын эсрэг бодлого, шударга байдлын зарчим ба журам (тухай бүрдээ шинэчлэгдэж байдаг)-ын дагуу компани, хувь хүнд хориг тавина;
- (e) Зөвлөхүүдийн данс бүртгэл болон зөвлөхийн сонгон шалгаруулалт, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-аас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулахыг АХБ, түүний төлөөлөгчид зөвшөөрөхийг зөвлөхөөс хүссэн заалтыг зөвлөхийг сонгон шалгаруулах баримт бичиг болон гэрээнд тусгасан байхыг шаардах эрхтэй.

### **Ёс зүйн хэм хэмжээ**

Туслан гүйцэтгэгч нь өөрийн ажилчид, мэргэжилтнүүд, дэд гэрээлэгч нарт ёс зүйн өндөр хэм хэмжээг баримталж, дээрэлхэх, ялгаварлан гадуурхах, зүй бус үйлдэл гаргах болон бэлгийн дарамт зэрэг аливаа хэлбэрээр дарамт үзүүлэхгүй байх, ямар ч үед ёс зүйгүй авирлах, дээрэлхэх, ёс зүйгүй үйлдэл гарах болон бэлгийн дарамт зэрэг аливаа дарамтаас ангид орчныг бүрдүүлж ажиллана. Туслан зөвлөх нь өөрийн ажилчид, эсвэл дэд гэрээлэгчийн аливаа хэлбэрээр ёс зүйгүй эсвэл зохисгүй авир гаргасан нь тогтоогдвол ажилтны эсвэл дэд гэрээлэгчийн гэрээг түдгэлзүүлэх эсхүл цуцлах зэрэг зохих арга хэмжээг авна.

Туслан зөвлөх нь өөрийн ажилчид, мэргэжилтнүүд, дэд гэрээлэгч нартаа дээрэлхэх, ялгаварлан гадуурхалт, зүй бус үйлдэл гаргах болон бэлгийн дарамт зэрэг аливаа хэлбэрийн дарамтаас урьдчилан сэргийлэх, мэдлэг олгох, ажлын байрны эерэг орчныг бүрдүүлэх сургалт зохион байгуулна. Туслан гүйцэтгэгч нь эдгээр сургалтын хөтөлбөрт хамрагдаж, дүүргэсэн ажилчид болон дэд гэрээлэгч нарын шинэчилсэн бүртгэлийг хөтөлж, бүртгэлийг бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу Захиалагч эсхүл Инженерт өгч байна.

Энэхүү ёс зүйн хэм хэмжээний хүрээнд дор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:

- (i) “Дээрэлхэлт” гэдэг нь нэг буюу хэд хэдэн этгээдийн хэн нэгнийг доромжлох, дорд үзэх, гомдоох, айлган сүрдүүлэх, ялгаварлан гадуурхах зэрэг байнгын давтамжтай аливаа хэлбэрийн бусдад хор учруулах үр дагавартай үйлдлээс бүрдсэн дарамтын хэлбэрийг хэлнэ. Үүнд тухайн хүнийг олны өмнө, хувь хүнд нь байнгын, үндэслэлгүй эсвэл тодорхойгүй шүүмжлэл хэлэх, доромжлох, нэр төрийг гутаах, хувийн дайралт болон/эсхүл даажигнах, улмаар тухайн хүний өөртөө итгэх итгэлийг аажмаар бууруулах, эсхүл үгүй хийхийг санаархах зэрэг үйлдэл байж болно. Зохих ёсоор илэрхийлсэн шүүмжлэл, эсрэг санал, гүйцэтгэлийн сөрөг үнэлгээ болон үүнтэй төстэй дүгнэлт нь дээрэлхэх, дарамт үзүүлэх үндэслэл биш.
- (ii) “Ялгаварлан гадуурхалт” гэдэг нь хувь хүн эсвэл бүлэг хүмүүсийн хоорондын зохисгүй ялгаварлан гадуурхах зан үйлийг хэлнэ. Үүнд арьсны өнгө, үндэс угсаа, үндэстэн, нийгэм, угсаатны гарал, шашин шүтлэг, ижил төстэй итгэл үнэмшил, хэл, улс төрийн болон бусад үзэл бодол, харьяалал, хүйс, хүйсийн баримжаа, бэлгийн чиг хандлага, гэр бүлийн болон нийгмийн байдал, эрүүл мэндийн байдал, бие махбодын хэмжээ, чадвар зэргээр ялгаварлахыг ойлгоно.
- (iii) “Дарамт” гэдэг нь ажил хийхэд саад учруулах, айлган сүрдүүлэх, дайсагналцах, доромжилсон ажлын орчныг бий болгох, хэл амаар, сэтгэл зүйн болон бие махбодын

- хувьд ямар ч үндэслэлгүй, хүсээгүй зан үйл юм. Дарамтад дээрэлхэх, бэлгийн дарамт үзүүлэх зэрэг орох ба үүгээр хязгаарлагдахгүй.
- (iv) “Шударга байдал” гэдэг нь АХБ-ны Авлигын эсрэг бодлого (1998 он, нэмэлт өөрчлөлт ордог), Шударга байдлын зарчим ба журам (2015 он, нэмэлт өөрчлөлт ордог) болон ёс зүйн өндөр хэм хэмжээг тууштай баримтлахыг хэлнэ.
- (v) “Ёс зүйгүй үйлдэл” гэдэг нь АХБ-ны зарчим, дүрэмд харш, хууль бус ёс зүйд нийцэхгүй, хүлээн зөвшөөрөгдөхгүй, зохисгүй үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ. Зохисгүй үйлдэл нь санаатай байх албагүй бөгөөд хайхрамжгүй, болгоомжгүй байдал, буруу менежментээс үүдэлтэй байж болно. Ёс зүйгүй үйлдэлд (i) эдгээр стандартууд эсвэл бусад дүрэм, журам, зааврыг даган мөрдөхгүй байх, эсвэл (ii) АХБ -ны дотоод болон гадаад орчинд АХБ-ны нэр хүндийг унагах, АХБ-ны бодлого, үйл явц, журмын шударга байдлыг алдагдуулах эрсдэлтэй аливаа үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүйг хэлэх ба үүгээр хязгаарлагдахгүй.
- (vi) “Хүндлэл” ажлын орчинд албан тушаалын шатлал, үүргээс үл хамааран бусад бүх хүмүүстэй мэргэжлийн, эерэг хандлагаар харилцахыг хэлнэ. Үүнд бусдад анхаарал халамж тавих, хүндэтгэлтэй хандах, үзэл бодлоо нээлттэй илэрхийлэх, түүнчлэн бусдыг шинж чанар, харьяалал, үзэл бодлоор нь алагчлан гадуурхахгүй харьцахыг хэлнэ.
- (vii) “Өс хонзон авах” гэдэг нь АХБ-ны аливаа хэлбэрийн (батлагдсан) буруутай үйл ажиллагааны мөрдөн шалгасан тайланд орсон эсхүл энэхүү үйл ажиллагаанд хамтран ажилласны улмаас уг үйл ажиллагааны мэдээлэгч, гэрч, эсхүл мэдээлэгч, гэрчтэй холбоотой болон бусад байдлаар албан ёсоор хууль бус үйлдлийн талаар гомдол гаргасан эсхүл гаргахаар төлөвлөж буй хэн нэгний эсрэг шууд болон шууд бус, санал болгосон, заналхийлсэн, хийсэн аливаа хор уршигтай үйл ажиллагааг хэлнэ. Үүнд дарамтлах, ялгаварлан гадуурхах, харгалзах ажлын байрны тодорхойлолтоос гадуур ажил олгох, ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг цуцлах, гүйцэтгэлийг зүй бусаар үнэлэх, цалингийн зохицуулалт хийх, эсхүл эрхийг нь хасах зэрэг үйлдлийг хэлэх ба үүгээр хязгаарлахгүй.
- (viii) “Бэлгийн дарамт” гэдэг нь бусдыг хүсээгүй байхад бэлгийн сэдлээ үг хэлээр, биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн, эсхүл бэлгийн харьцаанд орохоос өөр аргагүй байдалд оруулсан, мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх, боломж эдлүүлэх болзол болгон тавих, тулган шаардах зэрэг үйлдэл, эс үйлдэхийг хэлнэ.